

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.07.27

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 70 хуулийн 392 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 78 хуулийн 197 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 26 хууль буюу 33.3 хувь, 105 хэсэг, заалт буюу 26.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 56 /давхардсан тоогоор/ хуулийн 287 хэсэг, заалт буюу 73.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 14 хуулийн 18 хэсэг, заалтыг хяналтаас хассан тухай мэдээг ирүүлж, өмнөх онуудад хяналтаас хасагдсан 49 хуулийн 74 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	392
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	78	197
-	Хяналтанд байгаа	26	105

-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	49	74
-	2017 оны хагас жилээр хяналтаас хасагдсан	14	18
3	Засгийн газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	56	287

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 26 хуулийн 105 хэсэг, заалтаас 13 хуулийн 23 хэсэг, заалт буюу 21.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 11 хэсэг, заалт буюу 10.5 хувь нь хэрэгжих шатанд, 23 хуулийн 58 хэсэг, заалт буюу 55.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 12 хэсэг, заалт буюу 11.4 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 12 хуулийн 21 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар 8 хуулийн 13 заалт буюу 62.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс, 4 хуулийн 4 заалт буюу 30.8 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 хуулийн 4 заалт буюу 30.8 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 5 заалт буюу 38.4 хувь нь үнэлэх боломжгүй байна.

	Хууль /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	12	21	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	8	13	62.0
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	4	4	30.8
- Хэрэгжих шатанд	-	-	-
- Хэрэгжилт хангалтгүй	3	4	30.8
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	1	5	38.4

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд хяналтанд байгаа дараах 6 хуулийн 8 зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

1. Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай /2015.12.18/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2. “Гааль, татварын ерөнхий газар нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх зааврыг Гааль, татварын ерөнхий газрын дарга батална.”, мөн зүйлийн 4.4. “Гааль, татварын ерөнхий газрын дүрмийг Засгийн газар батална.”;
2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.05/ хуулийн 2 дугаар зүйл “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн

- тоо хэмжээ, төрөл, импортлогч хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.”;
3. Онцгой албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.05/ хуулийн 2 дугаар зүйл, “Онцгой албан татвараас чөлөөлөх суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашины тоо хэмжээ, төрөл, импортлогч хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.”;
 4. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай /2016.01.22/ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 6.1.1-д заасан хөнгөлөлт үзүүлэх журмыг Засгийн газар батална. /6.1.1-т Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 3.2.4-т заасан орлогоос санхүүжүүлэх/;
 5. Ирээдүйн өв сангийн тухай /2016.02.05/ хуулийн 16 дугаар зүйлийн 16.3. “Зөвлөх багийн гишүүдийг сонгон шалгаруулах, зөвлөх багийн ажиллах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”, 29 дүгээр зүйлийн 29.3. ”Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн хэлбэр, тайланд тавих тусгай шаардлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”;
 6. Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2017.06.08/ хуулийн 2 дугаар зүйл “Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд төлөгдсөн онцгой албан татварыг буцаан олгох журмыг Засгийн газар батална. /1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуульд заасны дагуу 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулсан онцгой албан татварыг татвар төлөгчид буцаан олгоно/ зэрэг болно.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 171 заалтыг хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 45 тогтоолын 106 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 20 тогтоолын 48 заалт буюу 28.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 57 /давхардсан тоогоор/ тогтоолын 123 заалт буюу 72.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 17 тогтоолын 27 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 31 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 20 тогтоолын 48 заалтаас 11 тогтоолын 18 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10 тогтоолын 22 заалт буюу 45.8 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 4.3 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

3.2. Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 17 тогтоолын 48 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 3 тогтоолын 13 заалт буюу нийт хяналтанд авсан тогтоолын 27.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл, 2 тогтоолын 3 заалт буюу 23.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 6 заалт буюу 46.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжээгүй, 2 тогтоолын 3 заалт буюу 23.0 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	17	48	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	3	13	27.0
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	3	6.2
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	6	12.5
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	-	-	-
- <i>Хэрэгжээгүй</i>	1	1	2.1
- <i>Үнэлэх боломжгүй</i>	2	3	6.2

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүргэлтэй, хяналтанд байгаа Улсын Их Хурлын дараах 16 тогтоолын 35 заалт буюу нийт хяналтанд байгаа тогтоолын 73 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

1. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2012.03.07 №23/ тогтоолын 2 дах заалт;
2. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай /2012.10.25 №52/ тогтоолын 1.1, 2.1, 3.1 дэх заалт;
3. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2014.04.17 №30/ тогтоолын 1.9, 1.13, 1.14 дэх заалт;
4. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2014.05.30 №39/ тогтоолын 1.1 дэх заалт;
5. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2015.02.17 №36/ тогтоолын 1.1, 1.6, 1.8, 1.9 дэх заалт;
6. Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2015.02.18 №42/ тогтоолын 2.1 дэх заалт;
7. Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай /2015.05.14 №49/ тогтоолын 2.1 дэх заалт;
8. Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг батлах тухай /2015.05.22 №51/ тогтоолын 2.1 дэх заалт;
9. Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай /2015.11.13 №103/ тогтоолын 3.1 дэх заалт;

10. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2015.12.03 №108/ тогтоолын 1.6, 1.7, 1.10 дах заалт;
11. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай /2016.02.05 №19/ тогтоолын 2.1, 2.2 дах заалт;
12. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.09.07 №40/ тогтоолын 2.1, 3.1 дэх заалт;
13. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2016.09.09 №47/ тогтоолын 1.а, 1.б, 1.в, 1.г заалт;
14. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2016.11.17 №69/ тогтоолын 1.2, 4.4 дэх заалт;
15. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2017.05.31 №41/ тогтоолын 1.1, 2.1 дэх заалт;
16. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2017.11.14 №69/ тогтоолын 1.1, 2.1, 3.1, 4.1 дэх заалт;

Мөн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолын 1.3, 3.3, 4.5 дах заалтын хэрэгжилтийн мэдээг 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн мэдээнээс зөрүүтэй ирүүлж, хэрэгжилтийн хувийг бууруулан үнэлсэн байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 100 тогтоолын 544 заалтыг хяналтанд авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 46 тогтоолын 186 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэнээс, хяналтанд байгаа 36 тогтоолын 124 заалт буюу 22.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 81 /давхардсан тоогоор/ тогтоолын 420 заалт буюу 77.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 36 тогтоолын 124 заалтаас 18 тогтоолын 41 заалт буюу 33 хувь нь бүрэн хэрэгжсэн, 21 тогтоолын 53 заалт буюу 42.7 хувь нь хэрэгжих шатанд, 14 тогтоолын 23 заалт буюу 18.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.8 хувь нь хэрэгжээгүй, 5 тогтоолын 6 заалт буюу 5 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн онуудад хяналтаас хасагдсан 13 тогтоолын 29 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 33 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Төсвийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Төсвийн байнгын хорооны 7 тогтоолын 29 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 2 тогтоолын 15 заалт буюу 52.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, дараах 5 тогтоолын 14 заалт буюу 48.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй орхигдуулсан байна. Үүнд:

1. Нийслэл Улаанбаатар хотын утаа, агаарын бохирдолтыг багасгах арга хэмжээний тухай /2010.01.12 №01/03/ тогтоолын 1.2/ дах заалт;
2. Засгийн газрын авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний тухай /2010.06.22 №14/ тогтоолын 1.2/, 1.3/ дах заалт;
3. Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2013.04.16 №04/04/ тогтоолын 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/ дах заалт;
4. Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2013.07.10 №01/ тогтоолын 1, 2, 3.2 дах заалт;
5. Чиглэл өгөх тухай /2017.02.07 №03/ тогтоолын 1.1/ 1.2/ 1.3/ дах заалт;

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 2 тогтоолын 15 заалтын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл, 2 тогтоолын 5 заалт буюу 33.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 4 заалт буюу 26.6 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 2 заалт буюу 13.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 3 заалт буюу 20.0 хувь нь үнэлэх боломжгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 6.7 хувь нь зөрчилтэй мэдээ ирүүлсэн байна.

	ТБХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	7	29	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	2	15	52.0
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	5	33.3
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	4	26.6
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	2	13.4
- <i>Хэрэгжээгүй</i>		-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	2	3	20.0
- <i>Зөрчилтэй</i>	1	1	6.7

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасах саналтай ирүүлсэн Төсвийн байнгын хорооны Чиглэл өгөх тухай 2014 оны 12 дугаар сарын 02–ны өдрийн тогтоолын 1.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг хянан үзэж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах” заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлэхдээ нийт орон нутгийн хэмжээнд бус зөвхөн 1 аймгийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэнг бүрэн хэрэгжсэн гэж үнэлэн, хяналтаас хасах үндэслэлгүй байна.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 4 хуулийн 4 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 2 тогтоолын 3 заалт, Төсвийн байнгын хорооны 1 тогтоолын 5 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэнг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, хяналтанд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан дахин ирүүлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх зэрэг дутагдалтай байна.

4/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ 2015.07.09	6.11. Энэ хуулийн 4.1.13, 4.1.14, 4.1.15, 6.2-т заасан падаан, баримт, гэрчилгээний загвар, албан татвар суутган төлөгч болон албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасахтай холбоотой журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалаар "Падаан, баримт, гэрчилгээний загвар" батлан хэрэгжүүлж байна.
2	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015.06.04	44.4 Цахим баримтыг тодорхойлох, түүнд тавих шаардлагыг тогтоох, цахим баримтыг хадгалах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Тус журмыг батлах ажлын хүрээнд Гааль, татварын ерөнхий газарт цахим баримтын стандарт нөхцөлийг тогтоох судалгаа хийгдэж байгаа. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн үндэслэн Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралтад нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем "ebarimt"-аас хэвлэгдэн гарч байгаа баримтыг анхан шатны баримтын жагсаалтад оруулан батлуулсан.
3	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2016.02.05	2.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг. "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем" /БТКУС/-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.	НӨАТ-ын тухай хуулийн 13.1.9-д заасны дагуу татвараас чөлөөлөх хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалтыг Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний 503 дугаар тогтоолоор, хуулийн 13.1.28-д заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөх сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийн жагсаалтыг Засгийн газрын 2016 оны 198 дугаар тогтоолоор, хуулийн 13.1.20-д заасан барааны жагсаалтыг Засгийн газрын 2013 оны 230 дугаар тогтоолоор тус тус батлуулсан. Мөн хуулийн 13.1.18, 13.1.21-д заасан НӨАТ-аас чөлөөлөгдөх Монгол Улсад үйлдвэрлэсэн жижиг дунд, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж болон инновацийн бүтээгдэхүүний жагсаалтыг гаргах ажлын хүрээнд салбарын яамдаас санал авахаар албан бичиг хүргүүлсэн.

4	<p>ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ 2016-02-05</p>	<p>2.Гаалийн албан татвараас чөлөөлөх суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн тоо хэмжээ, төрөл, импортлогч хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.</p>	<p>2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" хууль "Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай" хууль, "Онцгой албан татвараас чөлөөлөх тухай" хууль, Засгийн газрын 142-р тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Ази Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалтын үйлчилгээнд ашиглах зориулалттай суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийг татвараас чөлөөлөх "637" горимын кодыг КАИС бүрдүүлэлтийн программд оруулан 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Хэтмоторс ХХК-ийн импортлосон 52 ширхэг 1'285'859.17 ам.долларын үнийн дүнтэй Приус-30 маркийн тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татвараас чөлөөлсөн.</p>
---	--	---	--

Нийт 4 хуулийн 4 заалтыг хяналтаас хасах саналтай байна.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай 2015.06.16 №53	2.2.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгасан зорилго, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нийгмийн даатгалын сангийн болон улсын төсөвт тусгах, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их хурал, Засгийн газраас баталсан бодлогын бичиг баримтуудад нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн боловсруулах, тэтгэврийн олон давхаргат тогтолцоог бий болгох, тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тэтгэврийн хэмжээг зохистой түвшинд хүргэх зэрэг зорилтуудыг тусган ажиллаж байна. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын 2.2.1-ийн Зорилт 3-т “Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.” - Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.17-д “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилнэ.”, 3.3.24-т Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална. - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 14.2-т “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах” - Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 166-173 хэсэгт нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулахаар тус тус тусгасан. Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг тус яаманд байгуулан ажиллаж, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, НДС-аас олгох

			тэтгэврийн тухай, НДС-аас олгох тэтгэмжийн тухай, НДС-аас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нэрийн дансны аргаар бодох өндөр насны тэтгэврийн тухай, Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай зэрэг хуулиудын төслүүдийн эхний хувилбарыг боловсруулаад байна. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар өсгөж, 2008 оны түвшинд буюу 19 хувьд хүргэх, өндөр насны тэтгэврийн насыг 2018 оноос эхлэн жил бүр 6 сараар нэмэгдүүлэхээр ажиллаж байна.
2	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016.11.17 №69	4.1.улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх;	<p>2016 онд төрийн өмчит 38 хуулийн этгээд ашигтай ажиллаж байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54 компани цэвэр ашигтай ажилласан, алдагдалтай ажилласан хуулийн этгээд 18 болж 2016 оныхоос 16-аар буурсан байна. ТӨБЗГ-аас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 72 хуулийн этгээдийн цэвэр ашиг 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,442.7 сая төгрөгт хүрч, цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 3 дахин буюу 4,547.9 сая төгрөгөөр нэмэгдсэн.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг 2016 оны цэвэр ашгаас 15-30 хувиар тооцож, нийт 13.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор баталсан. 2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинтэй харьцуулахад 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.</p>

		<p>4.3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх;</p>	<p>ТӨБЗГ-аас 2016 оны 12 дугаар сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, зарцуулагдаагүй цалин хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд хогшил, эхлээгүй ажил, үйлчилгээний зардлыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх асуудлыг тусгасан “Албан даалгавар”-ыг гарган хэрэгжүүлж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 45 компанийн 32 ТУЗ, түүний дэд хороод, дотоод аудитын тайлан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны тайланг 2017 оны 01-02 дугаар сард хэлэлцэн дүгнэж, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>Тухайн компани ашиггүй ажилласан, их хэмжээний өр зээлтэй тохиолдолд ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүдийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзэн чөлөөлж, холбогдох хууль журмын дагуу шинээр сонгон шалгаруулж томилох чиглэл баримтлан ажиллаж байна. Холбогдох журам, үүрэг, чиглэлийг хангалтгүй биелүүлсэн төрийн өмчит 4 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 гишүүнийг чөлөөлж, хариуцлага тооцсон.</p> <p>ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг мөрдүүлэх арга хэмжээ авч, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өр авлага бууруулах, санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, хэмнэлтийн горимд ажиллах үүрэг чиглэлийг төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад өгч, үр дүнг тооцох шийдвэр гаргасан.</p>
<p align="center">Нийт 2 тогтоолын 3 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ
 /2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.03.26 №09/03	1.7/ Хүүхэд, хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр 2016-2024 он хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусган батлуулж, хэрэгжилтийг хангах;	<p>“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “Хүүхэд, хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр 2017-2021 он” хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөрийн 3 дугаар бүлэгт доорхи заалтуудыг тусган, батлуулж, хэрэгжилтийг зохион байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - 3.1.3.4.-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг хүүхдээ асрах, сэргээн засах, хөгжүүлэх чиглэлийн сургалтад үе шаттай хамруулах”; - 3.2.1.6.-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; - 3.2.1.7-д “Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах” зэрэг болно. <p>Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/-ийг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлууллаа. Үндэсний хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар дараах асуудлыг тусгав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 3.1.1.4-т “бодисын солилцооны эмгэг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээл, өвчин эмгэгийг оношлох эрт илрүүлэг, үзлэгт хамрагдах нөхцлийг бүрдүүлэх, эрсдэлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэх”; - 3.1.2.4-т “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг хүүхдээ хөгжүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр сургалтанд үе шаттай хамруулах”; - 3.2.1.3.-т “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; - 3.2.1.4-т “тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах”;

			<p>- 3.3.2.2. “бүх хүүхэд ялангуяа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэр бүл, сургууль, орон нутгийнхаа үйл ажиллагаанд бодитой оролцох боломж олгох, чадваржих олон талт арга хэмжээг зохион байгуулах” зэрэг болно.</p>
		<p>1.15.Шинээр барих шаардлагатай Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолборын барилга, Сүхбаатар дүүргийн 25 дугаар тусгай сургуулийн өргөтгөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн дотуур байрны барилга, байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн жагсаалтад оруулж, Монгол Улсын 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>2018 оны Төсвийн тухай хуульд "Цэцэрлэгийн барилга, 280 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар цэцэрлэг/" төсөл нь 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр, 2018 онд санхүүжих дүн 800.0 сая төгрөгөөр батлагдсан.</p> <p>Мөн 2018 оны төсвийн тухай хуульд "Тусгай сургууль, цэцэрлэгийн их засвар /Улаанбаатар, 25, 70, 186, 116, 63, 55 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэг/" төсөлд 500 сая төгрөг, "Тусгай сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, 25, 70, 186, 116, 63, 55 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэг/" төсөлд 500.0 сая төгрөг, "Тусгай сургуулийн сурагчдын автобус /Улаанбаатар, 25, 70, 186, 116, 63, 55 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэг/" төсөлд 1.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан.</p> <p>Сүхбаатар дүүргийн 25 дугаар тусгай сургуулийн өргөтгөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн дотуур байрны барилгыг 2018 оны улсын төсөвт тусгасан.</p>
		<p>1.16.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг бие даан нийгмийн харилцаанд оролцоход бэлтгэх, мэдлэг чадвар мэргэжлийн чиг баримжаа олгох нөхөн сэргээх сургалт, үйлдвэрлэл хөгжлийн төвийг шинээр байгуулахад шаардагдах санхүүжилтийг үе шаттай шийдвэрлэх;</p>	<p>2016 оны төсвийн тухай хуульд "БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн төвийн барилга"-ын монголын тал хариуцах гадна шугам сүлжээний зардал, зураг төсөл, /Улаанбаатар, Баянгол дүүрэг/" төсөл арга хэмжээ тусгагдаж 2016 онд 1857.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2018 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга /Дорноговь, Сайншанд сум/" төсөлд 1.0 тэрбум төгрөг, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/" төсөлд 1.5 тэрбум төгрөг тус тус батлагдсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хоорондын гэрээний дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд 30 сая ам долларын хөрөнгөөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барих ажил үргэлжилж байна. Каркас цутгалт, өрлөгийн ажил бүрэн дууссан. Барилга угсралт, дотор усан хангамжийн шугам, галын усны шугам угсралт, салхивчний ажлын явц 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Одоогоор нийт 70 сая юаны ажил хийгдсэн байна. Энэхүү төсөл 2016.09 сард эхэлсэн ба 2019.03</p>

			<p>сард дуусна.</p> <p>БНХАУ нь гэрээний төлөвлөсөн хугацаанаас 20 хоногийн өмнө ажлаа хийж гүйцэтгэж байна. Хятадын Худалдааны Яамны Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны газар болон Монгол Улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны (хуучнаар) 2016 оны 6 дугаар сарын 13-нд байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төвд тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-нд нийгмийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэлт гэрээ хийхээр 4 дүгээр сард хоёр талын уулзалт зохион байгуулаад байна.</p> <p>Түүнчлэн "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв"-ийн төслийн зураг төсөл боловсруулах гэрээнд заасан Монголын талын үүрэг болох зам гүүр, тохижилт, тоног төхөөрөмж, барилгын хяналтын зардал зэргийг санхүүжүүлэх боломжгүй байгаа учир БНХАУ-д шинээр төсөл боловсруулан Сангийн яамаар уламжлуулан БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яаманд хүргүүлээд байна.</p>
		<p>1.17/ Нийгмийн халамжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын хэрэгжилтийг ханган, үзүүлэх тусламж, дэмжлэгийн зардлыг Засгийн газрын гишүүний төсвийн багцаас гарган яаралтай шийдвэрлэх;</p>	<p>Тус арга хэмжээнд шаардагдах зардлыг 2017, 2018 оны батлагдсан төсөвт тусгаж шийдвэрлэсэн.</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан “Боловсролыг дэмжих үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг тус яамны зүгээс боловсруулан “Журам батлах тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд /хуучин нэрээр/, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалын төслийг 2013-2016 оны хооронд 3 удаа БСШУСЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд зорилтот бүлгийн суралцагчдад олгох сурах бичиг, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслийн зардлыг нийгмийн халамжийн асуудал болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас гаргахаар Нийгмийн халамжийн тухай хуулинд заасан.</p> <p>Гэвч БСШУСЯ-аас зөвхөн сурах бичгийг сургуулиудаар дамжуулан дунд, ахлах ангийн эмзэг бүлгийн суралцагчдын 40 хүртэлх хувьд олгож байгаа бөгөөд дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх төсөв, хөрөнгө боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгагдаагүй хэрэгжүүлэх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн бөгөөд журмыг батлагдаагүй болно.</p> <p>Харин тус яамны зүгээс Боловсролыг дэмжих үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн нэг болох төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж</p>

			байгаа хүүхдийн хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцасыг Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 247/А/163 “Зардлын норматив батлах тухай” хамтарсан тушаалын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусган хэрэгжүүлж байна.
		2. Тогтоолын биелэлтийг 2016 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Төсвийн байнгын хорооны хуралдаанд тус тус танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, спортын яаманд тус тус даалгасугай.	УИХ-ын Байнгын хорооны 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07, 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг 2016 онд ЗГХЭГ-т 2016-05-31-ний өдрийн 2/4603 тоотоор хүргүүлэн Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан болно.
Нийт 1 тогтоолын 5 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			